



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн санхүүжилтээр 2023 онд ашиглалтад оруулсан автозам болон зам гүүрний шинэчлэл, улсын чанартай автозамын их засварын ажлын хүрээнд бий болсон нийт 141,896,657,604.00 (нэг зуун дөчин нэгэн тэрбум найман зуун ерэн зургаан сая зургаан зуун тавин долоон мянга зургаан зуун дөрөв) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд (капиталжуулан) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн дарга С.Батболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001263

9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны .03 дугаар сарын... өдрийн
...112 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2023 ОНД АШИГЛАЛТАД ОРУУЛСАН
ШИНЭЭР БАРЬСАН АВТОЗАМ БОЛОН ЗАМ ГҮҮРИЙН ШИНЭЧЛЭЛ, УЛСЫН
ЧАНАРТАЙ АВТОЗАМЫН ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламж, / хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ/-ний нэр	Ашиглалтад орсон он	Хөрөнгийн нийт үнэ (төг)	Хүлээж авах байгууллага
1	Улсын чанартай А0501 дугаартай Улаанаатар- Өндөрхаан чиглэлийн 53- 63 км хатуу хучилттай авто замын хэсэгчлэн хүчитгэсэн их засвар	2023.11.27	3,397,459,741.00	Зам, тээврийн хөгжлийн яам
2	Улсын чанартай А0101 дугаартай Улаанаатар- Чойр чиглэлийн 124-126, 131-133.2 км хатуу хучилттай авто замын хэсэгчлэн хүчитгэсэн их засвар	2023.11.27	2,854,243,331.00	Зам, тээврийн хөгжлийн яам
3	Улсын чанартай А0202 дугаартай Мандалговь- Даланзадгад чиглэлийн 14-19 км хатуу хучилттай авто замын их засвар	2023.11.27	3,442,953,626.00	Зам, тээврийн хөгжлийн яам
4	Улсын чанартай А0202 дугаартай Мандалговь- Даланзадгад чиглэлийн 19-23 км хатуу хучилттай авто замын их засвар	2023.12.04	2,776,618,783.00	Зам, тээврийн хөгжлийн яам
5	Улсын чанартай А0501 дугаартай Улаанбаатар- Өндөрхаан чиглэлийн 226-237, 260-264 км хатуу хучилттай авто замын их засвар	2023.12.06	9,810,245,470.00	Зам, тээврийн хөгжлийн яам

6	Сэлэнгэ-Алтанбулаг чиглэлийн 0403 дугаартай олон улсын чанартай авто замаас Алтанбулаг хилийн боомт хүртэлх 1.65 км авто зам, тусгаарлах 4 эгнээ бүхий автозам, авто зогсоол	2023.12.15	11,135,240,131.60	Зам, тээврийн хөгжлийн яам
7	Улсын чанартай А0201 дугаартай Улаанбаатар-Мандалговь чиглэлийн 110-115.2 км хатуу хучилттай авто замын их засвар багц 1	2023.12.26	3,097,822,150.00	Зам, тээврийн хөгжлийн яам
8	Улсын чанартай А0201 дугаартай Улаанбаатар-Мандалговь чиглэлийн 193-198 км хатуу хучилттай авто замын их засвар багц 1	2023.12.26	3,097,374,346.00	Зам, тээврийн хөгжлийн яам
9	Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км авто замын багц-1 буюу 68.6 км авто замыг хэсэгчилэн эхний 50 км хатуу хучилттай авто зам	2023.12.28	34,160,074,924.00	Зам, тээврийн хөгжлийн яам
10	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67км хатуу хучилттай авто зам	2023.11.22	63,133,676,057.18	Зам, тээврийн хөгжлийн яам
11	Улсын чанартай А0301 дугаартай Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 318-326 км хатуу хучилттай авто замын хэсэгчлэн хүчитгэх их засвар багц 8	2023.12.18	4,990,949,044.60	Зам, тээврийн хөгжлийн яам
			141,896,657,604.00	
	Нийт хөрөнгийн дүн		(нэг зуун дөчин нэгэн тэрбум найман зуун ерэн зургаан сая зургаан зуун тавин долоон мянга зургаан зуун дөрвөн)	